



О.БАЯРЖАРГАЛ
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Нийгмийн
ажлын тэнхимийн багш,
докторант, ахлах
дэслэгч

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ БУУРУУЛАХАД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Хураангуй: “Нийгмийн ажил нь хүмүүсийн харилцаан дахь бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд нь туслах, хүмүүсийн сайн сайхны төлөө тэдний эрх, эрх чөлөө боломжийг нь өргөжүүлэх, тэднийг чадваржуулахад нь чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа”¹ хэмээн тодорхойлсон байдаг. Тодруулж хэлбэл нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээний нэг онцлог нь өөрчлөлтөнд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд үйлчлүүлэгчдийг өөрсдийг нь оролцуулах замаар тэднийг чадваржуулахад голлон анхаардаг юм. Иймд сургууль дээрх хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах чиглэлээр үйлчилгээ, үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхдээ хүүхэд бүр ямар нэг ялгаварлалгүйгээр, тэгш оролцох

боломжоор хангаж ажиллах нь сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулах ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: сургуулийн нийгмийн ажил, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, чадваржуулах, оролцоо

Нийгмийн ажил хэмээх энэхүү мэргэжил нь манай оронд 1997 оноос системтэйгээр хөгжиж эхэлснээс хойш өнөөг хүртэл 26 жилийн нүүрийг үзээд байна. Уг мэргэжлийн үндэс суурь нь анх сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээгээр эхэлсэн бөгөөд 2000 оны 4 дүгээр сарын 1-нд ЕБС-д нийгмийн ажилтан ажиллах тухай Гэгээрлийн болон ЭМНХ-ын сайдын хамтарсан 73/90 тоот тушаалаар гарснаар хууль эрх зүйн хувьд баталгаасан юм. Тухайлбал “.... хүүхдийн эрх ашиг нь зөрчигдсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авч эрсдлийн нөхцөл шалтгааны судлан тогтоох, мэргэшсэн байгууллагад мэдээллэх, зуучлах, сэтгэл зүйн засал хийх, нөхөн сэргээх, зөвлөх, нийгэмшүүлэх, чадваржуулах, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тэтгэлэг хөнгөлөлт үйлчилгээнд хамруулах” хэмээн заажээ. Зарим улс оронд /тухайлбал АНУ²/ сургуулийн нийгмийн ажлын

¹ Н.Нямдорж, Г.Түмэннаст, Б.Мягмарсүрэн “Нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага” УБ 2005 он

² Паул Аллен Мейрес, Роберт Вашингтон “Сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээ” УБ 2002 он

туршлагаас судлаж үзэхэд хүчирхийлэл үл хайхрах явдалд өртсөн хүүхэд залууст дараах төрлийн үйлчилгээнүүдийг үзүүлдэг байна.

Анхдагч урьдчилан сэргийлэлт:

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үл хайхрах, гадуурхах асуудлыг судалж тогтоох, улмаар хүүхдийн халамж хамгааллын байгууллагатай холбоо тогтоох

- Дээрх тохиолдлуудыг мэдээлэх, нөхцөл байдлыг тодорхойлох, мөн энэ чиглэлийн хуулийн хариуцлагын талаар холбогдох хүмүүст сургалт явуулах хөтөлбөр, арга зүйн материал бэлтгэх

- Сургуулийн хүрээнд хүчирхийлэл гадуурхах үйл хайхрах явдлыг мэдээлэх журмыг боловсруулж мөрдөх

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбогдох бодлого, дүрэм журмыг боловсруулахад санал оруулах, хэрэгжүүлэхэд оролцох

- Насанд хүрэгчдийн зүгээс хүүхдийг хүчирхийлсэн бу/у үл хайхран эрхийг нь зөрчсөн шинжтэй аливаа үйлдлийг тодорхойлон таних, энэ талаар хүүхэд залуучууд юу хийж болох талаар боловсрол гэр бүлийн хөгжил, амьдрах ухааны чиглэлтэй хөтөлбөрүүдийг агуулгад тусгаж оруулах

Хоёрдогч урьдчилан сэргийлэлт:

- Хүчирхийлэлд өртсөн болон эрх нь зөрчигдсөн сурагчидтай ганцаарчлан ажиллах, тэдний гэр бүлийг дэмжих богино хугацааны арга хэмжээ авах, бүлгээр ажиллах болон хүүхдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх

- Хүчирхийлэлд өртсөн болон үл хайхрагдсан, гадуурхагдсан хүүхдэд чиглэсэн шууд тусламж үзүүлэх талаар арга хэмжээ авах, анги хамт олон, эцэг эхтэй хамтран ажиллах, зөвлөгөө өгөх

- Хүүхэд, гэр бүл, сургууль, хууль хяналт, эмчилгээ үйлчилгээний байгууллагуудын хоорондох үйл ажиллагааг зохицуулах

Хямралын үеийн үйлчилгээ:

- Хүчирхийлэл, үл хайхрагдсан байдал гаргасан тохиолдлыг холбогдох хуулийн болон хүүхдийн халамж хамгаалал, эрүүл мэндийн байгууллагад мэдээлэх

- Сурагчдад сэтгэлзүйн болон бусад дэмжлэг туслалцаа үзүүлэх

- Шаардлагатай болон нөхцөл байдалд сургууль гэр бүлийн халамж хамгаалал, цагдаа, хууль хяналтын байгууллагуудын хооронд холбон зуучлах

- Хүүхэд, гэр бүл, сургууль, хууль хяналт, эмчилгээ үйлчилгээний байгууллагуудын хоорондох үйлчилгээг зохицуулах

- Хүүхдийг хүчирхийлэл, үл хайхрах тохиолдлыг мэдээлэх болон

бусад үйл явцад оролцсон багш болон бусад хүмүүст сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах

- **Шаардлагатай болон эмнэлэгийн үйлчилгээнд хүргэх унаа тээвэр гэх мэт бусад асуудлыг зохицуулах**

Эдгээр тусламж үйлчилгээнүүдийг хүргэх үүднээс юун түрүүнд сургууль түүний орчин, олон нийт, тэдгээрийн хөдлөл зүйг шинжлэн судалсны үндсэн дээр хүүхэд хамгааллын тусгайлсан хөтөлбөр үйлчилгээнүүдийг төлөвлөн боловсруулж, улмаар үйлчилгээний хэрэгжилт, үр дүнг үнэлж дүгнэх хэлбэрээр ажилладаг болохыг Америк дахь сургуулийн нийгмийн ажлын практик туршлага харуулж байна.

Үүний зэрэгцээ сургуулийн нийгмийн ажилтны зүгээс хүчирхийлэл, үл хайхрах явдалд өртөх эрсдэл бүхий хүүхэд залуус, тэдний хүрээлэн буй орчинд чиглэсэн хэрэгцээтэй тусламж үйлчилгээнүүдийг үзүүлэхдээ доорх 3 түвшин бүхий зохион байгуулалтын арга хэлбэрүүдийг ашигладаг.

Хувь хүнд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ

Энэ нь ганцаарчилсан хэлбэрээр нийгмийн ажлын мэргэжлийн тусламж үйлчилгээг хүргэх зохион байгуулалтын нэг арга хэлбэр бөгөөд хүчирхийлэлд өртсөн

болон өртөх эрсдэл бүхий хүүхэд, залуус тэдний гэр бүлийг үйл ажиллагаанд татан оролцуулах замаар тэдэнд тулгарсан хүндрэл бэрхшээлийг даван туулах асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг тусалцаа үзүүлэхэд чиглэгддэг. Зарим тохиолдолд хүчирхийлэл үл хайхрах явдалд өртсөн сурагчидтай уулзаж ярилцах, тэдний өмнө тулгарсан хүндрэлтэй нөхцөл байдлыг үнэлж тогтоох, улмаар сэтгэл зүйн зөвлөгөө, засал болон бусад төрлийн тусламж үйлчилгээг ганцаарчилсан байдлаар үзүүлснээр илүү үр дүнгээ өгдөг болох нь практик туршлагаас нотлогдсон байдаг.

Гэхдээ энэ нь нийгмийн ажилтан шаардлагатай бүх төрлийн тусламж үйлчилгээг бие даан ганцаараа үзүүлэх гэсэн ойлголт хараахан биш юм. Өөрөөр хэлбэл хүчирхийлэл, дарамтанд өртсөн сурагчдыг шаардлагатай бол өөр бусад мэргэжлийн хүмүүс, эмч, сэтгэл зүйч, өмгөөлөгч нарт холбон зуучлах, үйлчилгээнүүдийгхооронд нь зуучлах, хянах, үнэлэх хэлбэрээр ажиллах тохиолдол ч нэлээдгүй гардаг. Нөгөөтэйгүүр сургуулийн нийгмийн ажилтан хүчирхийлэл дарамтанд өртсөн хүүхдийн өмнөөс хийж гүйцэтгэх буюу асуудлыг шийдвэрлэх бус гагцхүү тэдний өөрсдийнх нь нөөц бололцоо, давуу талуудыг нь илрүүлэн дайчилж, оролцуулах замаар өөрчлөлтийг

өөрсдөө хийхэд нь дэмжин туслах буюу чадваржуулахад чиглэгддэг.

Түүнчлэн сурагчдад үүссэн нөхцөл байдлыг даван туулахад дэмжлэг үзүүлэх сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээ нь тухайн асуудалтай холбогдож байгаа болон нөлөөлж болох гэр бүл, эцэг эх, ойр дотны хүмүүс гэх мэт бусад бүх системд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх шаардлага ч тулгардаг. Учир нь хувь талаас нь асуудлыг шийдвэрлэсэн ч тухайн асуудлыг бий болгоход хүчтэй нөлөө үзүүлж буй систем /тухайлбал: гэр бүлийн систем/ талаас нь авч үзээгүйн улмаас асуудал дахин гарах магадлалыг нэмэгдүүлдэг. Тиймээс ч сургуулийн нийгмийн ажилтан нэг талаас хүчирхийлэлд өртсөн хүүхэд буюу үйлчлүүлэгчийг чадваржуулах нөгөө талаас гэр бүлийг бүхэлд нь нэгдмэл байдлаар авч үзэх хэрэгтэй болдог.

Бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээ

Сургуулийн нийгмийн ажилтнуудын зүгээс хувь хүн болон сурагчдад тохиолдсон хүндрэл бэрхшээлийг арилгах, учирсан болоод цаашид гарч болзошгүй эрсдлийг бууруулах үүднээс сурагчдын дунд жижиг бүлгүүдийг зохион байгуулан тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан үйлчилгээ хүргэх аргыг түгээмэл хэрэглэдэг. Учир нь сургуулийн ихэнх үйл

ажиллагаа бүлгийн хүрээнд зохион байгуулагддаг бөгөөд нийгмийн ажилтнуудын хувьд ч дээр аргыг хэрэглэхэд хамгийн тохиромжтой нь болж өгдөг. Хүүхдийн бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний онцлог нь нэг талаас тухайн бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулах, нөгөөтэйгүүр тухайн бүлгийн гишүүн болох хувь хүн буюу асуудал бүхий сурагчдад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх явдал юм. Иймд нийгмийн ажилтан бүлэгтэй ажиллахад хувь хүнтэй ажиллахаас илүү ур чадвар дадлага туршлага шаардагдахын зэрэгцээ зөвлөгч, холбогч, хамтрагч, дэмжин туслагч, удирдан чиглүүлэгч, зохион байгуулагч гэх мэт олон янзын үүргүүдийг давхар гүйцэтгэдэг.

Хүчирхийлэл дарамтанд өртөх гэх мэт ижил төстэй асуудал, хүндрэл бэрхшээл бүхий хүүхдүүд нэг бүлэгт нэгдсэнээр цагийг үр ашигтай өнгөрүүлээд зогсохгүй, тулгарсан асуудал бэрхшээл сэтгэл санаагаа бусадтай хуваалцах, бие биенээсээ суралцах, шаардлагатай дэмжлэгийг бие биедээ үзүүлж, ахиц дэвшил гарахад нөлөөлөхийн зэрэгцээ нийгмийн харилцааны дадлаа хөгжүүлэх, өөртөө итгэх чадвараа нэмэгдүүлэх зэрэг олон талын давуу боломжуудыг гишүүддээ олгож байдаг.

Гишүүдийн хэрэгцээ сонирхол, зорилго зорилт, шийдвэрлэх асуудал зэргээс

хамааран бүлгийн янз бүрийн хэлбэрүүдийг сургуулийн нийгмийн ажилтнууд зохион байгуулж ажилладаг. Тухайлбал: өсөлт төвт бүлэг, чиглүүлэх бүлэг, зөвлөх бүлэг гэхчлэн олон хэлбэрүүдийг дурьдаж болно.

Америкт сургуулийн нийгмийн ажлын хувь хүн болон бүлэгт чиглэсэн шууд үйлчилгээг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хувь хүнд чиглэсэн шууд үйлчилгээнд хүчирхийлэл дарамтанд өртсөн сурагчдын нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт хийж, сурагчдыг өөрчлөх, тухайн сурагчдад биечлэн зөвлөгөө өгөх, цаг завгүй ачаалалтай ажилладаг эцэг эхчүүдэд утсаар зөвлөгөө өгөх, сэтгэлзүйн дарамтанд орсон багш нартай уулзаж ярилцах зэргийг багтаасан байна.

Бүлэгт чиглэсэн шууд үйлчилгээнд хоорондоо нийлж нөхөрлөдөг хэсэг бүлэг хүүхдүүдтэй тулж ажиллах, тэдгээрийн эцэг эхэд ганцаарчилсан зөвлөгөө өгөх, сургуульд өөрчлөлт хийхийн тулд ажилчдыг идэвхжүүлэх уулзалт зохион байгуулах зэргийг багтаасан байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлийн үр дагавар

Хүчирхийллийн аливаа хэлбэр нь дангаараа үйлдэгдэггүй ихэвчлэн хавсарсан шинжтэй байдаг. Хүүхдийн эсрэг үйлдэгдэх аливаа хүчирхийлэл дарамт нь хүүхдийн

нийгэм сэтгэл зүйн байдал, бие бялдарын өсөлт хөгжил, зан төлвийн хүмүүжил зэрэгт олон янзын сөрөг үр дагаваруудыг авчирдаг.

Тухайлбал: Хүчирхийллийн улмаас

- Өөртөө итгэлгүй болж өөрийгөө үнэлэх үнэлэмж нь буурах
- Сурч боловсрох идэвхи сонирхол, чадвар зэрэг нь суларч сургуулиас завсардах
- Хүүхэд өөрийгөө буруутгаж амиа хорлох оролдлого хийх
- Хараа хяналтгүй болон гудамжинд гарах
- Сэтгэцийн саатал эсвэл сэтгэцийн байнгын согогтой болох
- Гэмт хэрэгт холбогдох
- Согтууруулах ундаа болон мансууруулах бодист донтох
- Бага насаа хүчирхийлэл дарамтан дунд өнгөрүүлсэн хүн хожим нь өөрөө бусдыг хүчирхийлэгч болох тохиолдолд цөөнгүй байдаг... гэх мэт.

Нийгмийн ажлын практикт үйлчлүүлэгчийг чадваржуулах тухай асуудлыг чухлаар авч үздэг бөгөөд энэхүү онол үзэл баримтлал нь “хүмүүс амьдралдаа тохиолдсон бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцох замаар өөрсдийн амьдралын чанараа сайжруулна” гэсэн санаан дээр тулгуурладаг. Тодруулж хэлбэл суралцагчдыг чадваржуулна гэдэг нь сургууль дээрх хүүхдийн эсрэг

хүчирхийллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс тэдний бусадтай харилцах харилцаа холбоог сайжруулж, бие даах чадварыг нь хөгжүүлэхийг хэлнэ. Парсон болон Симон нар “чадваржуулалт гэдэг нь сурагчид болон анги хамт олны эрх мэдлийг хөгжүүлж дээшлүүлэхэд чиглэсэн үйл явц” хэмээн тодорхойлсон байдаг. Сургууль дээрх хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээнд доор үйл ажиллагаануудаар дамжуулан сурагчдын оролцоог ханган чадваржуулна.

Чадваржуулах үйл явцдаа сурагчдын итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлсийг харгалзан оролцуулна. Учир нь тэдний өөртөө итгэх итгэл, өөрийгөө таних, өөрийнхөөрөө байх өөрийгөө хүлээн зөвшөөрөх гэх мэт чадварыг нь дэмжиж хөгжүүлснээр тэд чадваржаад зогсохгүй эргээд сургуулийнхаа орчинд ч тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлнэ.

Сурагчид бие биенээсээ суралцах тусламж дэмжлэг хүсэх, асуудлыг шийдвэрлэх шинэ чадварт суралцах өөртөө итгэлтэй байх зэрэг нь тэдний хамтын үйл ажиллагаа харилцааны явцад хөгжиж, харилцан туршлага солилцох нөхцөл болно. Хамтын үйл ажиллагааны явцад хүүхдүүд асуудлын учир шалтгааныг зөвхөн өөрийн байр сууринаас хараад зогсохгүй олон талаас нь олж харах чадварт суралцана. Сурагчид

бусдын дэмжлэг тусалцаатайгаар өөрсдийн өмнө тулгарч байгаа сургууль дээрх хүчирхийлэлтэй холбоотой асуудлын дотоод гадаад хүчин зүйлсийн талаар шүүмжлэлтэйгээр эрэгцүүлэн бодож сурахын зэрэгцээ өөрийн итгэл үнэмшил ойлголтонд үнэлгээ дүгнэлт өгч улмаар асуудалтай холбогдох мэдээ мэдээллийг олж харах үйл ажиллагаанд оролцох байдлаар чадваржина.

Сурагчид сургууль дээрх хүчирхийллийг бууруулахад чиглэсэн өөрчлөлт хийх үйл ажиллагаанд оролцсоноор үйлчилгээний үр шимийг хүртэх орчиндоо нөлөөлөх мэдлэг чадвараа дээшлүүлэх, улмаар өөрсдийнхөө нийтлэг эрх ашиг зорилгын төлөө төлөөх хамтын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж, түүндээ хяналт тавих чадвартай болно.

Дүгнэлт

Сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээнд сурагчдын талаас илүү хувь нь тодорхой хэмжээгээр оролцдог ч тэдний дунд зөвхөн мэдээлэл, үйлчилгээ хүлээн авах хэлбэрээр идэвхгүй байр сууринаас оролцох явдал нилээд байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах чиглэлээр сурагчдын идэвхи оролцоо бага байхын хирээр хүүхдийн аюулгүй байдал хамгааллын асуудал ч тэр хэрээр алдагдаж, улмаар сургууль дээр

хүүхдүүд бусдын хүчирхийлэлд өртөх явдал ч нэмэгдэж байна. Сурагчид хүчирхийллийг бууруулах чиглэлээр аливаа үйл ажиллагаанд оролцсоноор эргээд бусдын хүчирхийлэл дарамтанд өртөх санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж, сайн дураараа оролцох боломж нөхцлөөр хязгаарлагдмал байх, бусад хүмүүсийн зүгээс оролцоог нь үл тоомсорлож, идэвхигүй хандах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон хүүхдийн оролцооны талаар хангалттай ойлголт мэдлэггүй байх, тэдгээрийг ялгаварлан оролцуулах зэрэг хүндрэл бэрхшээлүүдтэй тулгардаг байна.

Хүүхдийн эсрэг хүчирийлийг бууруулахад чиглэсэн сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлж сурагчдын оролцоог нэмэгдүүлэхийн тулд юун түрүүнд тэдний хэрэгцээ сонирхолыг харгалзан үзэж, ямар нэг ялгаварлал, дарам шахалтгүйгээр оролцох боломж нөхцлийг бүрдүүлэх, улмаар хүүхдийн эсрэг хүчирийллийн хор уршиг, хүүхдийн оролцооны ач холбогдлыг сурагчид болон тэдэнтэй ойр дотно харилцаа холбоотой ажилладаг хүн бүрт ойлгуулан таниулж, оролцоог нь нэмэгдүүлж хамтран ажиллах шаардлагатай байна.